

БНМАУ-ЫН ХУДАЛДАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ЯАМНЫ САЙДЫН ТУЛАА, УЛААНБААТАР ХОТЫН
АРДЫН ДЭЛГЭГТЭГЭДНИЙ ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1990 оны 6 дугаар
сарын 8 ны өдөр

дугаар 141/111

Улаанбаатар
хот

Ашиглалтын захиргаа
байгуулах тухай

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1989 оны 299 дүгээр тогтоол,
Сайд нарын Зөвлөлийн тэргүүлэгчдийн хурлын мөн оны 57 дугаар
протоколыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Зөвлөлтийн барилгын хоёрдугаар трестийг монголын талд
шилжүүлэн авах бэлтгэл ажлыг хангах зорилгоор тус трестийн дэргэ-
лэх монгол ажилчдын захиргааг 1990 оны 6-р сарын 1-нээс ашиглал-
тын захиргаа болгон өргөтгөж ажиллуулахаар тогтоосугай.

2. Ашиглалтын захиргаа, харьяа байгууллагуудын 1990 оны орон
тоо, цалингийн санг нэгдүгээр хавсралтын ёсоор 340,0 мянган төг-
рөгөөр баталсугай.

3. Худалдаа, хамтын ажиллагааны яамны орлогч сайд н.Индэндорж,
Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны орлогч дарга
н.Найцан-нд даалгах нь:

а/трестийг монголын талд хүлээж авах бэлтгэл ажлыг хан-
гах ажлын явцад гарах асуудлыг тухай бүрд нь шуурхай авч үзэж
шийдвэрлэж байс угай.

б/трестээс энэ оны II улирлаас эхлэн шилжих прех үйлдвэр-
лэлийн баазын хүч чадал, ажиллах хүч, машин механизмг ашиглаж
1990-1991 онд барих барилга байгууламжийн хөрөнгийн эх үүсвэр,
шаардагдах материалын хэрэгцээний талаар санал боловсруулан
Нийгэм, эдийн засгийн хөгжлийн улсын хороонд оруулж шийдвэрлүүлсүгэ.

4. Ашиглалтын захиргаанд даалгах нь:

а/трестийг хүлээж авах бэлтгэлийг хангах асуудлыг Зөвлөл-

гийн барилгын хоёрдугаар трестийн захиргаатай хамтран салбар
наг бүр дээр зохион байгуулж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөв-
лөгөө гарган биедэлтийг сар дутам дүгнэж холбогдох арга хэмжээг
шуурхай авч хэрэгжүүлж байсугай.

6/1991 оны 12-р сар хүртэлх хугацаанд Зөвлөлтийн барил-
гын трестийн орон тоонд ба дагалдангаар ажиллах удирдах болон
үйлдвэрлэлийн инженер техникийн ажилтнуудын тоог 70-аас доошгүй
хувьд хүргэн сургах бэлтгэх арга хэмжээг авсугай.

в/ашиглалтын захиргаа, харьяа байгууллагуудад ажиллаж
байгаа нийт удирдах болон инженер техникийн ажилтнуудын агийн
засаг, санхүүгийн мөдлэгийг дээшлүүлэх, бүртгэл тооцооны ажилд
сургах хичээл сургалтыг зохион байгуулж явуулсугай.

г/бэлтгэл ажлыг хангахтай холбогду, дан удирдах дээд бай-
гууллагуудад оруулж шийдвэрлүүлэх асуудлыг цаг алдалгүй боловс-
руулж шийдвэрлүүлэх арга хэмжээг авч байсугай.

5. Дотоодын хөрөнгө оруулалтаар 1990-1991 онд барих барил-
гын ажлыг эрхлэн гүйцэтгэх аж ахуйн тооцоотой бие даасан барилга
утсралтын конторыг энэ оны III улирлаас эхлэн байгуулж ажиллуула-
хыг ашиглалтын захиргаанд зөвшөөрсүгэй.



УЛААНБААТАР ХОТЫН
АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ
ДАРГА
Н.БАВУУ

[Handwritten signature]



УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ДАРГА
Л.ЭНЭБИШ

[Handwritten signature]